



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/110/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)  
Дорноговь аймаг  
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа  
Утас: 70522734      Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn  
Аудитын менежер: Э.Энхцэцэг  
Утас: 70523020      Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn  
Аудитор:              Т.Мөнхтогтох  
Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

<b>Аудитын гэрчилгээ .....</b>	<b>3</b>
<b>Аудитын тайлан.....</b>	<b>5</b>
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал .....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.21 № 4-6/103  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ДАВААДОРЖ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Даваадорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 07-аас 2020 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөө, нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалахад оршино.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах;
- Шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих;
- Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх;
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах;
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах;
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “acalous” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 33 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 812,754.3 мянган төгрөгөөс тооцон 8,127.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 11,354.5 мянган төгрөгөөр тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 117,260.8 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	4,769.3	4,769.3	0.0
Үндсэн хөрөнгө	1,072,821.8	955,561.0	-117,260.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,077,591.2</b>	<b>960,330.4</b>	<b>-117,260.8</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,077,591.2	960,330.4	-117,260.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,077,591.2</b>	<b>960,330.4</b>	<b>-117,260.8</b>

Авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй.

Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлтийг авч үзвэл 22,325.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл акталж, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 3,094.4 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 2,000.0 хөрөнгийг худалдан авч, 337,526.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн зардал тооцсон байна.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй.

Өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 960,330.4 мянган төгрөг болж 117,260.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гараагүй байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 зориулалтад 1,014,381.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,012,381.4 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 2,000.0 мянган төгрөгийг бусад урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,014,577.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан товч тайлбарлах. /материаллаг дүнтэй хэлбэлзэл бүхий орлогын нэр төрөл, шалтгаан/

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,014,381.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. /цалин хөлс болон нэмэгдэл урамшил 797,689.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 99,711.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 26,036.2 мянган төгрөг, хангамж бараа материал 51,562.2 мянган төгрөг, нормативт зардал 800.0 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 17,000.0 мянган төгрөг, томилолт зочны зардал 13,783.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 5,798.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 2,000.0 мянган төгрөг/ нийт дүнгээр 196.3 мянган төгрөг хэмнэгдэж үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,895.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,895.4 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 1,895.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,895.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Үүнд: 1. 2019 онд ээлжийн амралтын мөнгийг тооцохдоо ажилтнуудад олгосон хоолны хөнгөлөлтийг оруулж бодсоноор 27 хүнд нийт 1,895.4 мянган төгрөгийг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55.2 “Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно”, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 4 “Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн

хөнгөлөлт/-ийг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Үндсэн хөрөнгийн дансанд 70 нэр төрлийн 243,970.2 мянган төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгүүд байна. Үүнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу үнэ, ашиглах жилд өөрчлөлт оруулах, дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 222.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосноос 222.0 мянган төгрөгийг барагдуулсан, 175.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс 175.8 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

#### 1.1 Илрүүлэлт:

*Тээвэр шатахуунд харьцуулалтын аргыг ашиглахгүйгээр шууд худалдан авалт хийсэн.*

*Энэ нь (Иж бүрэн байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ТБОНӨБАҮХАТХ-ийн 8.1.1 “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 33.1 “бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно”, Төсвийн тухай хуулийн 24.4 “төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөө санхүүжилт гаргахыг хориглоно”, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоол “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.1.1 “төсвийн жилийн эхэнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон батлагдсан төсвийг хэрхэн зүй зохистой удирдаж авлага, өр төлбөр шинээр үүсгэхгүй байх талаар төлөвлөгөө гаргаж мөрдүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.*

#### 1.2 Эрсдэл:

*Ашиг сонирхлын зөрчил үүсэх, хууль журам мөрдөгдөхгүй байх.*

#### 1.3 Өгсөн зөвлөмж:

*Тээвэр шатахууны зардалд ТБОНӨБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах.*

*1.4 Байгууллагаас өгсөн харуу, тайлбар: Шүүхийн тамгын газар нь 2019 онд тээвэр шатахуун худалдан авах тендер зарлаагүй болно.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,769,390.00</u></b>	<b><u>4,769,390.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4,769,390.00	4,769,390.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	4,769,390.00	4,769,390.00
35420	Аж ахуйн материал	4,232,550.00	4,232,550.00
35470	Бусад хангамжийн материал	536,840.00	536,840.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,072,821,828.47</u></b>	<b><u>955,561,011.62</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,072,821,828.47	955,561,011.62
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,022,285,161.67	905,116,011.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	859,623,545.78	859,623,545.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-630,000.00	-31,512,544.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,675,000.00	93,350,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-95,946,850.21	-93,350,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,227,636.01	186,273,436.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-104,376,105.33	-166,367,981.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	101,008,859.60	101,008,859.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,809,974.18	-45,286,687.92
39209	Зам, гүүрийн байгууламж	1,105,950.00	1,105,950.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-184,325.04
39217	Ном	407,100.00	455,760.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	50,536,666.80	50,445,000.00
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-733,333.20	-825,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	50,445,000.00	50,445,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,077,591,218.47</u></b>	<b><u>960,330,401.62</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,077,591,218.47</u></b>	<b><u>960,330,401.62</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,077,591,218.47	960,330,401.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	396,557,624.46	396,557,624.46
51101	Өмч: - төрийн	396,557,624.46	396,557,624.46
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	118,435,321.09	1,174,504.24
51210	Өмнөх үеийн үр дүн	118,435,321.09	118,435,321.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-117,260,816.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	562,598,272.92	562,598,272.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,077,591,218.47</u></b>	<b><u>960,330,401.62</u></b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,031,209,750.00</b>	<b>1,018,192,010.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,802,150.00</b>	<b>3,614,210.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8,802,150.00	3,614,210.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,802,150.00	3,592,910.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,802,150.00	3,592,910.00
120009	Бусад орлого	00.00	21,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,022,407,600.00</b>	<b>1,014,577,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,022,407,600.00	1,014,577,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,022,407,600.00	1,014,577,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,074,677,233.68</b>	<b>1,135,452,826.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,074,677,233.68</b>	<b>1,135,452,826.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,074,677,233.68	1,133,256,441.38
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	787,167,000.00	797,689,700.00
210101	Үндсэн цалин	609,250,000.00	609,190,500.00
210102	Нэмэгдэл	138,150,000.00	149,728,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,205,000.00	25,662,000.00
210104	Урамшуулал	12,562,000.00	13,108,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,518,200.00	99,711,200.00
210201	Тэтгэврийн даатгал	63,732,200.00	67,283,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,696,500.00	8,106,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,157,200.00	6,485,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,539,300.00	1,621,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,393,000.00	16,213,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,768,987.06	26,036,214.53
210301	Гэрэл, цахилгаан	3,976,000.00	3,142,197.53
210302	Түлш, халаалт	22,939,787.06	21,182,817.00
210303	Цэвэр, бохир ус	2,853,200.00	1,711,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	55,580,760.00	52,081,950.00
210401	Бичиг хэрэг	15,077,700.00	14,902,700.00
210402	Тээвэр, шатахуун	24,948,800.00	24,948,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,446,700.00	8,446,700.00
210404	Ном, хэвлэл	199,700.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	264,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,667,860.00	3,519,750.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,754,000.00	15,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,224,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	21,530,000.00	10,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13,284,300.00	13,783,900.00
210702	Дотоод албан томилолт	13,284,300.00	13,783,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,232,700.00	5,798,200.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,214,700.00	3,214,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,496,000.00	1,555,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	462,000.00	207,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	247,500.00
210807	Газрын төлбөр	00.00	300,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>63,571,286.62</b>	<b>122,355,276.85</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,571,286.62	122,355,276.85
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>2,196,385.47</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>2,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,000,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>196,385.47</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	196,385.47
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>-43,467,483.68</u></b>	<b><u>-117,260,816.85</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>21,675,913.99</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	163,225.00	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	21,512,688.99	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-21,675,913.99</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>-65,143,397.67</u></b>	<b><u>-117,260,816.85</u></b>

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,026,805,894.00</b>	<b>1,014,577,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,246,346.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,246,346.00	00.00
120009	Бусад орлого	1,246,346.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,025,559,548.00</b>	<b>1,014,577,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,022,407,600.00	1,014,577,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,022,407,600.00	1,014,577,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,151,948.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,151,948.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,018,426,594.00</b>	<b>1,012,577,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,018,426,594.00</b>	<b>1,012,577,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,015,274,646.00</b>	<b>1,010,381,414.53</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	787,652,000.00	797,689,700.00
210101	Үндсэн цалин	609,735,000.00	609,190,500.00
210102	Нэмэгдэл	138,150,000.00	149,728,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,205,000.00	25,662,000.00
210104	Урамшуулал	12,562,000.00	13,108,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,518,200.00	99,711,200.00
210201	Тэтгэврийн даатгал	63,732,200.00	67,283,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,696,500.00	8,106,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,157,200.00	6,485,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,539,300.00	2,702,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,393,000.00	15,133,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,282,200.00	26,036,214.53
210301	Гэрэл, цахилгаан	3,976,000.00	3,142,197.53
210302	Түлш, халаалт	20,453,000.00	21,182,817.00
210303	Цэвэр, бохир ус	2,853,200.00	1,711,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	53,255,900.00	51,562,200.00
210401	Бичиг хэрэг	14,902,700.00	14,902,700.00
210402	Тээвэр, шатахуун	24,948,800.00	24,948,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,464,700.00	8,446,700.00
210404	Ном, хэвлэл	199,700.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	264,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	3,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,021,000.00	15,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,491,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	21,530,000.00	10,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13,284,300.00	13,783,900.00

210702	Дотоод албан томилолт	13,284,300.00	13,783,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,232,700.00</b>	<b>5,798,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,214,700.00	3,214,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,496,000.00	1,555,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	462,000.00	207,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	247,500.00
210807	Газрын төлбөр	00.00	300,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,228,346.00</b>	<b>00.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,228,346.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,151,948.00</b>	<b>2,196,385.47</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,151,948.00</b>	<b>2,000,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,151,948.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>196,385.47</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	196,385.47
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>8,379,300.00</u></b>	<b><u>2,000,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,379,300.00</b>	<b>2,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,379,300.00</b>	<b>2,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,379,300.00</b>	<b>2,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,379,300.00	2,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-8,379,300.00</u></b>	<b><u>-2,000,000.00</u></b>

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	346,112,624.46	455,407,526.00	183,578,718.76	985,098,869.22
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>346,112,624.46</b>	<b>455,407,526.00</b>	<b>183,578,718.76</b>	<b>985,098,869.22</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-65,143,397.67	-65,143,397.67
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>396,557,624.46</b>	<b>562,598,272.92</b>	<b>118,435,321.09</b>	<b>1,077,591,218.47</b>
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>396,557,624.46</b>	<b>562,598,272.92</b>	<b>118,435,321.09</b>	<b>1,077,591,218.47</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>396,557,624.46</b>	<b>562,598,272.92</b>	<b>118,435,321.09</b>	<b>1,077,591,218.47</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-117,260,816.85	-117,260,816.85
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>396,557,624.46</b>	<b>562,598,272.92</b>	<b>1,174,504.24</b>	<b>960,330,401.62</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,014,577,800.00	1,014,381,414.53	196,385.47	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,577,800.00	1,014,381,414.53	196,385.47	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,012,577,800.00	1,012,381,414.53	196,385.47	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	797,689,700.00	797,689,700.00	00.00	100.0
210101	Үндсэн цалин	609,190,500.00	609,190,500.00	00.00	100.0
210102	Нэмэгдэл	149,728,300.00	149,728,300.00	00.00	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,662,000.00	25,662,000.00	00.00	100.0
210104	Урамшуулал	13,108,900.00	13,108,900.00	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,711,200.00	99,711,200.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	67,283,600.00	67,283,600.00	00.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,106,900.00	8,106,900.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,485,500.00	6,485,500.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,621,400.00	2,702,200.00	-1,080,800.00	166.6
210205	Эрүүл мэндийн даатгал	16,213,800.00	15,133,000.00	1,080,800.00	93.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,232,200.00	26,036,214.53	195,985.47	99.3
210301	Гэрэл, цахилгаан	3,945,100.00	3,142,197.53	802,902.47	79.6
210302	Түлш, халаалт	20,575,900.00	21,182,817.00	-606,917.00	102.9
210303	Цэвэр, бохир ус	1,711,200.00	1,711,200.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	51,562,200.00	51,562,200.00	00.00	100.0
210401	Бичиг хэрэг	14,902,700.00	14,902,700.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	24,948,800.00	24,948,800.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,446,700.00	8,446,700.00	00.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	264,000.00	264,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	3,000,000.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,000,000.00	17,000,000.00	00.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	7,000,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	13,784,300.00	13,783,900.00	400.00	100.0
210702	Дотоод албан томилолт	13,784,300.00	13,783,900.00	400.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,798,200.00	5,798,200.00	00.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,214,700.00	3,214,700.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,555,800.00	1,555,800.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,200.00	207,200.00	00.00	100.0

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	247,500.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	300,000.00	300,000.00	00.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2000000.00</b>	<b>2000000.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	00.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,014,577,800.00</b>	<b>1,014,577,800.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,014,577,800.00</b>	<b>1,014,577,800.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,014,577,800.00	1,014,577,800.00	00.00	100.0